

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН “ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 01.

Өлгий хот

Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус компани нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 33,871,378.99 төгрөгийн цэвэр ашигтай гарсан боловч 1,776,022,613.24 төгрөгийн дансны өглөгтэй, татварын албанд төлөх 516,455,854.33 төгрөгийн, нийгмийн даатгалын байгууллагад төлөх 35,316,190.67 төгрөгийн өртэй, банкнаас авсан богино хугацаат зээл 726,832,543.80 төгрөг ба урт хугацааны 1,592,218,632.19 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, хүүний өглөг 78,288,027.58 төгрөг байгаа нь Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан шаардлагыг хангахгүй байгаа тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосугай.

2. Энэ тухай хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдэхийг компанийн гүйцэтгэх захирал М.Тилеубердид үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.МАНЕН